



Хэрэглэгчийн гарын авлага

НӨАТ, нэхэмжлэх, тулгалтын систем

Хувилбар: 1.0
Шинэчилсэн: 2026-06-30

Гарчиг

Гарчиг.....	2
1. Танилцуулга.....	4
Юу хийдэг вэ?	4
Хэнд зориулсан вэ?	4
2. Quick Start — Хурдан эхлэх	5
Алхам 1: Нэвтрэх	5
Алхам 2: ААН/Байгууллага сонгох	5
Алхам 3: Банкны данс бүртгэх	5
Алхам 4: Хуулга оруулах	5
Алхам 5: Борлуулалт/Худалдан авалтаа харах	5
3. Хэрэглэгчийн гарын авлага.....	6
3.1 Нэвтрэлт ба аюулгүй байдал	6
Нэвтрэх	6
3.2 ААН/Байгууллагууд.....	6
ААН-ийн төлвүүд	6
Шинэ ААН идэвхжүүлэх	6
3.3 Дансны хуулга	6
Хуулга импортлох.....	6
Хуулга харах.....	7
3.4 Борлуулалт.....	7
Дэлгэцийн бүтэц.....	7
Багана тус бүрийн тайлбар.....	7
Сэргээх vs Шинэчлэх.....	7
3.5 Худалдан авалт	8
3.6 Харилцагчид.....	8
Багана тус бүрийн тайлбар.....	8
3.7 Хянах самбар	8
Үндсэн үзүүлэлтүүд (5 карт).....	8
Жагсаалт хэсгүүд	9
3.8 Санал хүсэлт.....	9
Шинэ санал хүсэлт илгээх	9
Хариу унших	9
Thread-ийн төлвүүд	9
4. Аюулгүй байдал ба нууцлал	10
4.1 ИТС нэгдсэн нэвтрэлт	10

4.2 Нууц үгийн нууцлал	10
4.3 Дансны хуулгын нууцлал.....	10
4.4 Е-Баримтын мэдээлэл	10
5. Төлбөрийн нөхцөл.....	11
5.1 Үнэ	11
5.2 Төлбөр төлөх алхамууд.....	11
5.3 Олон ААН-ийн бөөн төлбөр.....	11
Жишээ.....	11
5.4 Төлбөр хаашаа төлөх вэ?.....	12
5.5 Жил солих ба урьдчилж төлөх	12
6. Алдаа шийдвэрлэх (FAQ).....	13
Нэвтэрч чадахгүй байна.....	13
ААН идэвхгүй харагдсаар байна	13
Сар "Шинэчлэх" товч дарахад өгөгдөл шинэчлэгдэхгүй	13
Дансны хуулга оруулахад баганаа таниулж чадахгүй байна	13
Зөрүү гарч байна	13
7. Холбоо барих.....	14

1. Танилцуулга

Vatify нь Монголын татвар төлөгч ААН/Байгууллагуудад зориулсан НӨАТ, нэхэмжлэх, дансны хуулгын тулгалтын бүтэн систем юм. Та Е-Баримтын мэдээллээ автомат татаж, банкны хуулгатайгаа тулгаж, авлага/өглөгийн үлдэгдлийг хянах боломжтой.

Юу хийдэг вэ?

- Е-Баримт системээс борлуулалт, худалдан авалт, нэхэмжлэхийг автомат татна.
- Банкны дансны хуулгаа Excel/CSV-ээр оруулна.
- Харилцагч тус бүрээр Е-Баримт ↔ Хуулгын тулгалт автоматаар хийнэ.
- Хянах самбараас авлага, өглөг, НӨАТ, төлөгдөөгүй нэхэмжлэхийг шууд харна.
- Санал хүсэлтийн дотоод системээр админтай шууд харилцана.

Хэнд зориулсан вэ?

НӨАТ суутгагч ААН, нягтлан бодогч, бизнесийн эзэд, дотоод тооцоо хариуцагчид.

2. Quick Start — Хурдан эхлэх

Vatify-г 5 алхамын дотор ашиглаж эхлэх боломжтой.

Алхам 1: Нэвтрэх

1. Хөтчөөрөө Vatify хаягт зочилно.
2. "Нэвтрэх" дэлгэц дээр Е-Баримтын системийн и-мэйл болон нууц үгээ оруулна.
3. "Нэвтрэх" товчийг дарна.

Аюулгүй байдал: Та манай системд өөр нэр, нууц үг үүсгэх шаардлагагүй. Е-Баримтын системийн нэгдсэн нэвтрэлтээр баталгаажих ба нууц үгийг манай app-д хадгалахгүй.

Алхам 2: ААН/Байгууллага сонгох

4. Эхний удаа нэвтрэхэд таны эзэмшилд бүртгэгдсэн ААН/Байгууллагууд автоматаар жагсаалт болж харагдана.
5. Ажиллахыг хүсэж буй ААН-ийг сонгоно.
6. Сонгосон ААН нь дээд талын баруун буланд харагдаж, бүх дараагийн үйлдэл энэ ААН-ийн хүрээнд хийгдэнэ.

Анхаар: Шинэ ААН эхэндээ "Идэвхгүй" төлөвтэй ирнэ. Төлбөрөө төлсний дараа админ идэвхжүүлдэг.

Алхам 3: Банкны данс бүртгэх

7. "Дансны хуулга" хуудас руу очно.
8. "Шинэ данс" товчийг дарна.
9. Банкны нэр, дансны нэр, дансны дугаар оруулна.
10. "Хадгалах" товчийг дарна.

Алхам 4: Хуулга оруулах

11. Банкаас экспорт хийсэн Excel/CSV хуулгын файлыг бэлдэнэ.
12. "Хуулга оруулах" товчийг дарж файлаа сонгоно.
13. Багана таних дэлгэц дээр Огноо, Гүйлгээний утга, Дебет, Кредит баганыг тааруулна.
14. "Импортлох" товчийг дарна.

Аюулгүй байдал: Импорт хийсэн дансны хуулга нь зөвхөн таны хөтөч дотор хадгалагдана. Манай серверт огт хадгалагдахгүй ба бусад хэрэглэгч үзэх боломжгүй.

Алхам 5: Борлуулалт/Худалдан авалтаа харах

15. "Борлуулалт" эсвэл "Худалдан авалт" хуудас руу очно.
16. Хайх он, сараа сонгоно (хүсвэл "Бүх сар").
17. "Шинэчлэх" товчийг дарж Е-Баримтаас шинэхэн өгөгдөл татна.
18. Харилцагч сонгож тулгалтын дэлгэрэнгүйг харна.

3. Хэрэглэгчийн гарын авлага

3.1 Нэвтрэлт ба аюулгүй байдал

Vatify нь E-Баримт системийн нэгдсэн нэвтрэлт (Single Sign-On)-ыг ашигладаг. Энэ нь та тусдаа бүртгэл үүсгэх шаардлагагүй гэсэн үг.

Нэвтрэх

19. И-мэйл хаяг — E-Баримт системд бүртгэгдсэн и-мэйл хаягаа оруулна.
20. Нууц үг — E-Баримт системийн нууц үгээ оруулна.
21. "Нэвтрэх" товчийг дарахад системийн нэгдсэн нэвтрэлтийн серверээр шалгуулна.

Аюулгүй байдал: Таны нууц үг манай апп болон манай серверт огт хадгалагдахгүй. Шалгуулах болгонд E-Баримт системд илгээж, тэндээс ирсэн token-оор л таныг таньна.

Аюулгүй байдал: Token-ы хугацаа дуусахад автоматаар шинэчлэгдэнэ. Та идэвхгүй болсон үед автоматаар гарна.

3.2 ААН/Байгууллагууд

Нэвтрэхэд таны E-Баримт системд эзэмшилтэй бүх ААН автоматаар татагдан жагсаалт болж харагдана. Та нэг дор олон ААН-д хандах боломжтой.

ААН-ийн төлвүүд

Төлөв	Тайлбар
Идэвхтэй	Төлбөр төлөгдсөн, бүх боломжтой үйлдлийг хийж болно.
Идэвхгүй	Төлбөр төлөгдөөгүй эсвэл шинээр нэмэгдсэн ААН.
Түр зогссон	Зөрчил гарсан, эсвэл админ түр зогсоосон.
Хүсэлт явуулсан	Та идэвхжүүлэх хүсэлт явуулсан, админ хариу хүлээж байна.

Шинэ ААН идэвхжүүлэх

22. "ААН/Байгууллагууд" хуудас руу очно.
23. Идэвхгүй ААН-ийн хажуу талын "Идэвхжүүлэх хүсэлт" товчийг дарна.
24. Төлбөр төлсний дараа админ идэвхжүүлнэ.

3.3 Дансны хуулга

Та банкны дансны хуулгаа Excel эсвэл CSV форматаар импортлох боломжтой. Импортлогдсон хуулга нь зөвхөн таны хөтөч (browser)-ийн дотоод санах ойд хадгалагдана.

Аюулгүй байдал: Дансны хуулга манай сервер дээр огт хадгалагдахгүй. Зөвхөн таны хөтөч дотор (IndexedDB) хадгалагддаг тул өөр төхөөрөмжөөс үзэхэд дахин импортлох шаардлагатай.

Хуулга импортлох

25. "Дансны хуулга" хуудсыг нээнэ.

26. Дээд талаас банкны данс сонгоно. Хэрэв байхгүй бол "Шинэ данс" товчоор бүртгүүлнэ.
27. "Импортлох" товчийг дарна.
28. Excel/CSV файлаа сонгоно.
29. Багана таних дэлгэц дээр баганануудыг зөв тааруулна — Огноо, Гүйлгээний утга, Дебит, Кредит, харилцагчийн РД.
30. "Импортлох" товчоор баталгаажуулна.

Зөвлөмж: Системд аль хэдийн орсон гүйлгээтэй ижил мөр давтан орохгүй. Давхар оруулсан тохиолдолд автоматаар алгасна.

Хуулга харах

Жагсаалтаас тухайн сараар шүүх, харилцагч/гүйлгээний утгаар хайх боломжтой. Дансны үлдэгдэл, нийт орлого, нийт зарлагыг доод хэсэгт харуулна.

3.4 Борлуулалт

Е-Баримт системээс татагдсан борлуулалтын мэдээлэл (НӨАТ-той падаан, НӨАТ-гүй POS, нэхэмжлэх) бүгдийг харилцагчаар нэгтгэж харуулна.

Дэлгэцийн бүтэц

- Зүүн талд — Харилцагчуудын жагсаалт (нэр, регистр, тоо, нэхэмжлэхийн дүн, Е-Баримтын дүн, хуулгын дүн, зөрүү).
- Баруун талд — Сонгосон харилцагчийн гүйлгээ бүрийн дэлгэрэнгүй (огноо, баримтын дугаар, төрөл, дүн, тулгалт).
- Дээд талд — Сар сонгох товчнууд, "Бүх сар" сонголт, хайлт.

Багана тус бүрийн тайлбар

Багана	Тайлбар
Худалдан авагч	Харилцагчийн нэр.
Регистр №	Татвар төлөгчийн дугаар.
Тоо	Тухайн харилцагчтай хийсэн гүйлгээний нийт тоо.
Нэхэмжлэх	Илгээсэн нэхэмжлэхүүдийн нийт дүн.
Е-Баримт	НӨАТ-той падаан + НӨАТ-гүй POS + хаагдсан нэхэмжлэхийн нийт дүн.
Хуулга	Тухайн харилцагчаас орсон төлбөрийн нийт дүн (банкны хуулгаас).
Зөрүү	Е-Баримт – Хуулга. Эерэг = таны тал илүү. Сөрөг = харилцагчийн тал илүү.

Сэргээх vs Шинэчлэх

Товч	Үйлдэл
Сэргээх	Хөтөчийн кэш + серверийн кэшээс уншина. Е-Баримтаас шинээр татахгүй.

Шинэчлэх	Кэшийг алгасаж Е-Баримтаас шинээр татна (нэг сар сонгосон үед идэвхтэй).
----------	--

Кэшийн зан үйл: Хуудас руу шилжих болгонд Е-Баримтаас дахин татахгүй. Зөвхөн Сэргээх/Шинэчлэх товч дарсан үед л сервертэй холбогдоно.

3.5 Худалдан авалт

Борлуулалттай ижил бүтэцтэй боловч таны худалдан авсан барааны мэдээллийг харуулна. Нийлүүлэгч ААН-ууд харилцагчид болж нэгтгэгдэнэ.

- Нийлүүлэгч — Бараа/үйлчилгээ авсан ААН-ийн нэр.
- Е-Баримт — Авсан НӨАТ-той падаан, нэхэмжлэхийн нийт дүн.
- Хуулга — Тухайн нийлүүлэгчид хийсэн төлбөрийн нийт дүн.
- Зөрүү — Е-Баримт – Хуулга. Сөрөг = таны тал илүү төлсөн.

3.6 Харилцагчид

Бүх харилцагчийн жагсаалт. Тухайн харилцагчтай хийсэн борлуулалт, худалдан авалтын нийт дүнг харуулна.

Багана тус бүрийн тайлбар

Багана	Тайлбар
Регистр	Татвар төлөгчийн дугаар.
Нэр	Харилцагчийн ААН-ийн нэр.
Борлуулалт	Та энэ харилцагчид зарж борлуулсан нийт дүн.
Худалдан авалт	Та энэ харилцагчаас худалдан авсан нийт дүн.
Зөрүү	Борлуулалт – Худалдан авалт. Эерэг = таны тал илүү.

3.7 Хянах самбар

Тухайн сараар хамгийн чухал KPI-уудыг нэг дэлгэцэнд харуулна.

Үндсэн үзүүлэлтүүд (5 карт)

Карт	Утга
Борлуулалт (сар)	Сонгосон сард Е-Баримтад бүртгэгдсэн нийт борлуулалт.
Худалдан авалт (сар)	Сонгосон сард Е-Баримтад бүртгэгдсэн нийт худалдан авалт.
Авлагын үлдэгдэл	Төлөгдөөгүй борлуулалтын нэхэмжлэхийн үлдэгдлийн нийлбэр.
Өглөгийн үлдэгдэл	Төлөгдөөгүй худалдан авалтын нэхэмжлэхийн үлдэгдлийн нийлбэр.
НӨАТ зөрүү	Борлуулалтын НӨАТ – Худалдан авалтын НӨАТ. Эерэг = төлөх, сөрөг = буцаан авах.

Жагсаалт хэсгүүд

- Төлөгдөөгүй / дутуу төлөгдсөн нэхэмжлэх — талбар, огноо, харилцагч, нэхэмжлэх, төлсөн, үлдэгдэл.
- Зөвхөн хуулгад (Е-Баримт бүртгэгдээгүй) — банкны хуулгад орсон ч Е-Баримт байхгүй харилцагчид.
- Зөвхөн Е-Баримт-д (хуулгад бүртгэгдээгүй) — Е-Баримт байгаа ч банкаар хараахан төлөгдөөгүй харилцагчид.

3.8 Санал хүсэлт

Систем дотроос шууд админд санал, асуудал, хүсэлтээ илгээж, хариу авах боломжтой. Бичлэг бүрт thread үүсгэгдэж хариу солилцох боломжтой.

Шинэ санал хүсэлт илгээх

31. "Санал хүсэлт" хуудас руу зүүн хажуугийн цэснээс орно.
32. Дээд талын "+ Шинэ" товчийг дарна.
33. Гарчиг ба дэлгэрэнгүй тайлбараа бичнэ.
34. "Илгээх" товчийг дарна.

Хариу унших

Дээд талын баруун буланд харагдах хонхны дүрс дээр шинэ хариу ирэхэд улаан badge гарна. Дарж дэлгэрэнгүйг харна.

Thread-ийн төлвүүд

Төлөв	Тайлбар
Шинэ	Илгээсэн боловч админ хараахан хариу өгөөгүй.
Хүлээгдэж буй	Админ хүлээн авч хариу өгөх явцад байна.
Хаагдсан	Асуудал шийдвэрлэгдсэн, thread хаагдсан. Шинэ асуудал гарвал шинээр илгээнэ.

4. Аюулгүй байдал ба нууцлал

4.1 ИТС нэгдсэн нэвтрэлт

Vatify нь Монгол Улсын Татварын Ерөнхий Газрын (ИТС/Е-Баримт) нэгдсэн нэвтрэлтийн системийг ашигладаг. Та нэвтрэхдээ Е-Баримт системийн и-мэйл, нууц үгээ ашиглана.

Аюулгүй байдал: Vatify тусдаа нэр, нууц үг ҮҮСГЭХГҮЙ. Та Е-Баримт системд нэвтэрдэг л бол шууд Vatify-д хандах боломжтой.

4.2 Нууц үгийн нууцлал

Манай systems-д таны нууц үгийг ХАДГАЛДАГГҮЙ.

- Нэвтрэх товч дарахад таны и-мэйл/нууц үгийг шууд Е-Баримт системийн нэвтрэлтийн серверт дамжуулна.
- Серверээс ирсэн token-ийг л манай систем ашиглана.
- Манай мэдээллийн сан болон лог файлд таны нууц үг ОГТ үлдэхгүй.

Аюулгүй байдал: Та хүсвэл Е-Баримт системд нэвтэрч нууц үгээ солих боломжтой. Бид солихыг шаарддаг үйлдэл байхгүй.

4.3 Дансны хуулгын нууцлал

Та банкны хуулгаа Excel/CSV-ээр импортлоход тэр мэдээлэл нь манай сервер рүү огт явдаггүй.

- Хуулга нь зөвхөн таны хөтөч (browser)-ийн дотоод IndexedDB санд хадгалагдана.
- Бид серверт хадгалдаггүй учир бид тэр мэдээллийг үзэх боломжгүй.
- Хөтчийн кэшийг арилгах эсвэл нууц горимоор нэвтрэхэд хуулгын мэдээлэл устгах тул дахин импортлох шаардлагатай.
- Олон төхөөрөмж ашиглах бол төхөөрөмж тус бүрт импортлох ёстой.

Аюулгүй байдал: Дансны хуулгын мэдээлэл нь бизнесийн нууц мэдээлэл бөгөөд та өөрөө хяналт тавьдаг. Манай админ ч энэ мэдээлэлд хандах боломжгүй.

4.4 Е-Баримтын мэдээлэл

Е-Баримтаас татагдсан борлуулалт, худалдан авалт, нэхэмжлэхийн мэдээллийг манай сервер дээр түр кэш хийнэ. Энэ нь дахин дахин ИТС рүү хүсэлт явуулахгүй байх зорилготой.

- Өнгөрсөн саруудын мэдээлэл (тайлан хаагдсан саруудын) — бүх удаа хадгалагдана.
- Идэвхтэй сарын мэдээлэл — 5 минутын дотор шинэчлэгдэнэ.
- Кэш бүхэлдээ encrypted form-оор ирдэг ба бид өөрсдийн passphrase-ээр decrypt хийдэг.
- Зөвхөн таны эзэмшилтэй ААН-уудын мэдээлэлд хандах эрхтэй (token шалгуулна).

5. Төлбөрийн нөхцөл

5.1 Үнэ

Vatify-н төлбөр маш энгийн. Нэг ААН/Байгууллагын нэг санхүүгийн жилийн төлбөр 22,000 ₮ байна.

Үзүүлэлт	Дэлгэрэнгүй
Нэг ААН-ийн төлбөр	22,000 ₮ / санхүүгийн жил
Төлбөрийн давтамж	Жилд 1 удаа
Хугацаа	Зөвхөн тухайн санхүүгийн жил (1-р сараас 12-р сар)
Урьдчилж төлөх	Дараа оны төлбөрийг урьдчилж төлөх боломжтой
Сонголт	Зөвхөн ашиглахаар сонгосон ААН-ийн төлбөрийг л төлнө

Жишээ 1: Хэрэв та 5 ААН-тай боловч зөвхөн 2-ыг идэвхтэй ашиглах бол $2 \times 22,000 = 44,000$ ₮ төлнө.

Жишээ 2 — Санхүүгийн жил: 2026 оны 12-р сард төлсөн төлбөр нь зөвхөн 2026 онд хамаарна. 2027 он эхлэх үед дахин төлөх шаардлагатай. Та хүсвэл 2026 болон 2027 оны төлбөрийг хамтад нь урьдчилж төлж болно.

5.2 Төлбөр төлөх алхамууд

- 35. "ААН/Байгууллагууд" хуудас руу очно.
- 36. Идэвхжүүлэхийг хүсэж буй ААН-уудаа тэмдэглэнэ.
- 37. Нийт төлөх дүнг харна (тэмдэглэгдсэн ААН-ийн тоо $\times$ 22,000).
- 38. Заасан банкны данс руу төлбөрийг шилжүүлнэ.
- 39. Төлбөр баталгаажсаны дараа сонгосон ААН-ууд автоматаар идэвхжинэ.

5.3 Олон ААН-ийн бөөн төлбөр

Хэд хэдэн ААН-ийн төлбөрийг нэг гүйлгээгээр төлөх боломжтой. Энэ тохиолдолд таны төлбөрийг зөв ААН-уудад хувиарлахын тулд гүйлгээний утга дээр РД (регистрийн дугаар)-уудыг тусгаарлаж бичнэ.

Жишээ

ААН	Регистр
Тэст ХХК	6673538
Дэлгүүр ХХК	5012345
Кафе ХХК	3398765

3 ААН-ийг бөөн төлөхөд:

- Нийт дүн: $3 \times 22,000 = 66,000$ ₮
- Гүйлгээний утга: 6673538, 5012345, 3398765

Анхаар: РД-уудыг таслал (,) болон цэг таслал (;), эсвэл зайгаар тусгаарлаж болно. Шилжүүлж байгаа дүн нь РД-уудын тоо $\times$ 22,000 байх ёстой.

Зөв жишээ: Гүйлгээний утга: "6673538, 5012345, 3398765" — дүн: 66,000 ₮.

Буруу жишээ: Гүйлгээний утга: "Vatify төлбөр" гэх мэт ерөнхий тайлбар бичсэн тохиолдолд төлбөрийг зөв хувиарлах боломжгүй.

5.4 Төлбөр хаашаа төлөх вэ?

Системд заасан банкны данс руу шилжүүлнэ. Хүлээн авагчийн нэр болон дансны мэдээлэл "ААН/Байгууллагууд" хуудасны "Төлбөр төлөх" хэсэгт харагдана.

5.5 Жил солих ба урьдчилж төлөх

Төлбөр нь санхүүгийн жил (1-р сараас 12-р сар)-аар тооцогддог. Жилийн эцэст 30, 14, 7 хоногийн өмнө шинэ оны төлбөрийн сануулга мэдэгдэл ирнэ. Шинэ оны 1-р сард ААН автоматаар "Идэвхгүй" төлөв рүү шилжинэ, хэрэв тухайн оны төлбөр төлөгдөөгүй бол.

- Хугацаа дуусах эрсдэл — мэдэгдэл топбар дээр харагдана.
- Урьдчилж төлөх — Тухайн он дуусахаас өмнө дараа оны төлбөрийг урьдчилж төлж болно.
- Шинэ онд төлөх — 1-р сард төлсөн ч тухайн санхүүгийн жилийн бүх хугацаанд хүчинтэй.
- Жил дунд орох — 2026 оны 6-р сард шинээр төлсөн ч 2026 оны эцэс хүртэл хүчинтэй, дүн өөрчлөгдөхгүй (22,000 ₮ хэвээр).

Анхаар: 12-р сард төлсөн төлбөр зөвхөн тухайн оны эцэс хүртэл хүчинтэй. Дараа оны төлбөрийг тусад нь буюу урьдчилгаагаар хамт төлөх шаардлагатай.

6. Алдаа шийдвэрлэх (FAQ)

Нэвтэрч чадахгүй байна

- И-мэйл/нууц үгээ Е-Баримтын системд зөв ажиллаж байгаа эсэхийг шалгана.
- Е-Баримт серверийн боломжтой эсэхийг шалгана.
- Хөтчийн кэш цэвэрлэж дахин оролдоно.

ААН идэвхгүй харагдсаар байна

- Төлбөр төлсний дараа автоматаар идэвхжих ч 24 цаг хүртэл хугацаа шаардаж болно.
- Гүйлгээний утганд РД зөв бичигдсэн эсэхийг шалгана.
- Хэрэв 24 цаг өнгөрөөд идэвхжээгүй бол санал хүсэлт илгээнэ.

Сар "Шинэчлэх" товч дарахад өгөгдөл шинэчлэгдэхгүй

- Серверийн кэш 5 мин дотор шинэчлэгддэг тул дахин оролдоно.
- "Хэт олон шинэчлэл" мэдэгдэл харагдвал заагдсан секунд хүлээнэ.

Дансны хуулга оруулахад баганаа таниулж чадахгүй байна

- Excel/CSV файлын эхний мөр гарчиг (header) байх ёстой.
- Огноо нь YYYY-MM-DD эсвэл DD/MM/YYYY форматтай байх ёстой.
- Дебит/Кредит баганад зөвхөн тоо байх ёстой (тэмдэгт оруулахгүй).

Зөрүү гарч байна

- Гүйлгээний утганд харилцагчийн РД оруулсан эсэхийг шалгана.
- Хагас төлсөн нэхэмжлэхэд "Үлдэгдэл"-ийн дүн зөрүүтэй гарч магадгүй.
- Тулгалт хийгдээгүй мөрнүүдийг "Зөвхөн хуулгад" эсвэл "Зөвхөн Е-Баримт-д" жагсаалтаас харна.

7. Холбоо барих

Тусламж эсвэл санал хүсэлт байвал систем дотор "Санал хүсэлт" цэснээс шууд илгээнэ. Бид хариуг 1-2 ажлын өдрийн дотор өгөхийг хичээх болно.

Хурдан тусламж шаардлагатай тохиолдолд систем дээр мэдэгдэхээс гадна и-мэйлээр бид рүү бичиж болно.

И-мэйл: support@vatify.mn

Веб: <https://vatify.mn>